



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018.. он 05.. дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар X 947  
947


Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Я.САНЖМЯТАВ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Малын зүй бус хорогдоос урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, хохирлыг барагдуулах, мал төллөлтийн явц, энэ талаар малчдад үзүүлж байгаа дэмжлэг, улсын хэмжээнд тариалалтад зориулсан шатахууны болон үрийн нөөц, шатахуун, түлшний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан хаврын тариалалтын талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хаврын тариалалтын бэлтгэл ажил зэрэг асуудлаар Танаас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамаар бэлтгүүлэн үүгээр уламжлан хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

004944



МОНГОЛ УЛСЫН  
ХУНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2018. 05. 03 № 01/1543  
танай 2018.04.06 -ны № X7Г/698-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Я.Санжмятуваас Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд хандаж 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 19 тоот албан бичгээр хүргүүлсэн малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, хохирлыг барагдуулах, мал төллөлт, хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцтай холбоотой асуулгад дараах хариултыг хүргүүлж байна. Үүнд:

1. Малын зүй бус хорогдоос урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, хохирлыг хэрхэн барагдуулах, мал төллөлтийн өнөөгийн байдал, хичнээн төл авах урьдчилсан тооцоо болон хаврын мал төллөлттэй холбогдуулан малчдад ямар дэмжлэг үзүүлж байгаа талаар:

Манай улсад 2018 он гарсаар нийт 13 аймгийн 43 суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин бүртгэгдсэнээс 04 дүгээр сарын 27-ны байдлаар 3 аймгийн 5 суманд хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна.

2018 онд шүлхийн 7.2 сая тун вакцин худалдан авахаар төлөвлөснөөс эхний ээлжийн 500.0 мянган тун вакциныг 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч, Өмнөговь, Дундговь, Булган, Дорнговь, Төв, Хэнтий, Орхон аймгуудад хуваарилан олгож вакцинжуулалт 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр таригдаад байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 дугаар ээлжийн 4 сая тун вакциныг Монгол улсын босоо тэнхлэг дагуу Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Дорнговь аймгуудыг хамруулан зүүн болон төвийн бүсийн зарим аймгуудад гарсан шүлхий өвчний эрсдэлээс төвийн зарим мөн баруун бүсийн аймгуудын мал сүргийг хамгаалах зорилгоор хамгаалалтын зурvas үүсгэн нийт 17 аймгийн 118 сумын бог 3.1 сая, бод 2.5 сая буюу нийт 5.6 сая толгой мал хамруулахаар тарилгын ажлыг зохион байгуулж байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шүлхий болон шүлхийгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, мэдээллийг иргэдэд хүргэн ажиллахын зэрэгцээ малчид, малын эмч нарт зориулан сүүлийн үеийн мэдээлэл, мэдлэгээр баяжуулсан зурагт үзүүлэнг тараахаас гадна холбогдох мэдээллийн сайтад нээлттэй байршуулаад байна.

00000768

Шүлхий өвчинтэй тэмцэхдээ дэлхий нийтэд баримталдаг 3 арга байдаг.

Үүнд:

- Өвчлөл гарсан даруйд тухайн баг, сум, тосгоны цаашилбал аймаг бүсийн түвшинд хүртэл хорио цээрийн дэглэм хэрэгжүүлэн мэдрэмтгий бүх малыг устгаад нөхөн төлбөр олгодог
- Хорион цээрийн дэглэм хэрэгжүүлээд өвчний шинж тэмдэг бүхий малыг түүвэрлэн устгадаг
- Хорио цээрийн дэглэм хэрэгжүүлдэг боловч огт устгадаггүй зэрэг болно.

Монгол улсын хувьд дээрх 3 хувилбарын 2 болон 3 дахь хувилбарыг хослуулан хэрэглэх бодлого барьж байна. Тухайлбал: Зүүн бүсэд шүлхий орогномол байдалтай болоод байгаа энэ үед заавал устгахгүй байх бөгөөд төвийн бүсийн хувьд баруун бүсээ хамгаалах зорилгоор хорио цээр, вакцинжуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ өвчний илэрхий шинж тэмдэгтэй малыг ялган устгах арга барилыг сонгон ажиллаж байна.

2017 оны эхний хагас жилд гарсан малын гоц халдварт өвчинтэй тэмцэх зардал болон малын нөхөн олговорт Засгийн газрын нөөц сангаас нийт 4.4 төгрөгийг шийдвэрлэсэн. 2018 он гарсаар 5798 малыг зориудын устгалд оруулсан, нөхөн олговор олгоогүй байна.

2017 оны мал тооллогын дүнгээр 28.2 сая хээлтэгч тоологдоноос 22.0 орчим сая төл хүлээн авах урьдчилсан тооцоо гарсан. 04 дүгээр сарын 26-ны байдлаар оны эхний нийт хээлтэгчийн 43.5 хувь буюу 11 сая 863.2 мянган эх мал төллөж 11 сая 328.2 мянган төл бойжиж байна. Монгол улсын мал сүрэг одоогийн байдлаар 36.8 мянган ботго, 134.7 мянган унага, 344.2 мянган тугал, 6 сая 343.4 мянган хурга, 4 сая 514.4 мянган ишигээр ёсёж байна. Төл бойжилт 97.0 хувьтай байна. Мал төллөлт 7 хоногт 2.0 сая орчмоор нэмэгдэж байна.

2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалд УОК-оос "Шуурхай бүлэг" томилон үнэлгээ хийсэн дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын 3 удаагийн тогтоолоор Улсын нөөцийн 10500 тн өвсийг үнэгүй, 8000 тн тэжээлийг 50 хувь хямруулах, зарим аймгийн ХХААГ, ОБГ, хүн эмнэлэгт ариутгалын болон үйлчилгээний автомашин 27-г, 5 нэр төрлийн 41.0 сая төгрөгийн малын эм бэлдмэл, 1.4 тн ариутгалын бодис, ОБГ-уудад 6.0 тн хүнсний зүйл, аймаг бүрт 110.0 сая төгрөг олгоход зориулж нийт 9.2 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргасан нь өнгөрч буй өвлүүн хүндрэлийг даван туулахад ач холбогдолтой боллоо.

Мөн олон улсын хүрээнд НҮБ-ын ХХААБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраас Архангай, Төв, Булган, Өвөрхангай, Завхан аймгийн 5 сумын нийт 504 малчин өрхөөс мах худалдан авч Улаанбаатар хот болон Завхан аймгийн төвийн эмзэг бүлгийн өрхүүдэд тараах, өвс, тэжээлийн тусlamж үзүүлэхэд 696.0 сая төгрөгийн, МУЗН-ээс 15 аймгийн 78 сумын 4500 өрхөд 1 тэрбум 267.8 сая төгрөгийн бэлэн мөнгө болон тэжээл, хүнсний багцын, Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллагаас Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өвөрхангай зэрэг 6 аймгийн 26 сумын 1840 өрх тус бүрт 300 кг тэжээл буюу 264.0 сая төгрөгийн тус тус тусlamж үзүүлэхэд нийт 2 тэрбум 227.8 сая төгрөг зарцууллаа.

ОХУ-аас өвс, тэжээл импортлох болон үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахаар малчид, фермерүүдэд нийлуулэх аж ахуйн нэгжийн төсөл сонгон шалгаруулалтад тэнцсэн 34 аж ахуйн нэгжтэй 40.0 тэрбум төгрөгийн Бодлогын болон Зээлийн гэрээг байгуулан нийт санхүүжилтийн 78.0 хувь буюу 31.1 тэрбум төгрөгийг ААН-үүдэд шилжүүлээд байна.

2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар нийт 41428.8 тонн тэжээл импортолсон, үүнээс хивэг 16511.0 тн, хорголжин 11622.0 тн, тэжээлийн эрдэнэшиш 3052.9 тн, шар буурцагны шахдас 1059.0 тн, овъёос 8026.9 тн, тэжээлийн нэмэгдэл бэлдмэл 1157.0 тн байна. Тэжээлийн импорт 7 хоногт 650-2000 тн-ийн хэлбэлзэлтэй байна.

Борлуулалтыг тэжээлийн төрлөөр нь авч үзвэл нийт 24678.5 тн тэжээл борлогдсоноос: хивэг 13812.2 тн, хорголжин 8072.3 тн, овъёос 2177.5 тн, өвс 1360.3 тн, бусад тэжээл 609.9 тн байна. Нийт борлуулалтын 56.4 хувь нь бэлэн мөнгөөр, 31.6 хувь нь зээлээр, 8.0 хувь нь ноосны урамшууллаар, 3.7 хувь нь малаар хийгдсэн байна.

Өвөлжилтийн хундрэлийг даван туулахад зориулж авсан дээрх арга хэмжээнүүдийн үр дунд улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 1 сая 419.2 мянган малын хорогдолтой байгаа нь оны эхний нийт малын 2.1 хувийг эзэлж байгаа нь хэвийн гэж үзэж болохоор байна.

2. Улсын хэмжээнд үр тарианы тариалалтад зориулж шатахууны болон үрийн нөөц бэлэн эсэх талаар:

Энэ онд улсын хэмжээгээр 408.9 мянган га-д үр тариа, үүнээс 390.4 мянган га-д улаанбуудай, 15.5 мянган га-д төмс, 8.4 мянган га-д хүнсний ногоо, 32.0 мянган га-д тэжээлийн таримал, 41.9 мянган га-д тосны ургамал, 6.5 мянган га-д жимс жимсгэнэ, нийтдээ 513.2 мянган га-д тариалалт хийнэ.

Тариалалтад нийтдээ 60.0 мянган тонн буудайн үр шаардагдахаас аж ахуйн нэгжууд 2017 оны ургацаас 24.0 мянган тонныг нөөцөлж, Тариалан эрхлэлтийг дэмжих сан дотоодын ургацаас 23.8 мянган тонн, ОБЕГ-ын Улсын үрийн нөөцийн салбар 3.0 мянган тонн, нийтдээ 50.8 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн болно.

Тиймээс дутагдах үрийн нөөцийг нэмж бүрдүүлэхээр төсвийн болон ТЭДС-ийн хөрөнгөөр 5.9 мянган мянган тонн элит, 2.1 мянган тонн сортын, нийтдээ 8.0 мянган тонн буудайн үрийт импортоор нийлүүлэх ажлыг зохион байгуулж байгаагийн зэрэгцээ хэрэгцээт үрийнхээ тодорхой хувийг өөрийн зардлаар шинэчлэх хүсэлт ирүүлсэн б аж ахуйн нэгжид 2.0 мянган тонн үрийн буудай импортоор авах зөвшөөрөл олгосноор 2018 оны тариалалтад шаардагдах 60.0 мянган тонн буудайн үрийн нөөцийг 100 хувь бүрдүүлэв.

Түүнчлэн тариалалтыг хэвийн явуулахад 7.8 мянган шатахуун шаардагдах тооцоо гарсан бөгөөд улсын хэмжээгээр 35-40 хоногийн нөөцтэй гэсэн мэдээлэл байна. Тиймээс ТЭДС-гаас "НИК" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 3.5 мянган тонн шатахууныг орон нутгийн ШТС-даар дамжуулан тариаланчдад 50 хувийн урьдчилгаатай зээлээр олгохоор шийдвэрлэж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

3. Шатахуун, түлшний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан хаврын тариалалтад Монгол Улсын Засгийн газраас ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа талаар:

2017 оны ургацаас гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн хүнсний улаанбуудайнд нийтдээ 7.8 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосны зэрэгцээ 2018 оны тариалалтад зориулан ТЭДС-гаас олгох 31.8 мянган тонн үрийн буудайн үнийн хөнгөлөлтөд 7.0 тэрбум төгрөг зарцуулж мөнгөн бус дэмжлэг үзүүлэх шийдвэрийг гаргасны дагуу хэрэгжилтийг зохион байгуулав.

Энэхүү шийдвэрийн дагуу аж ахуйн нэгжүүдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулах, технологийн ажилбаруудыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор юны өмнө хаврын тариалалтад зориулан олгох үрийн буудайн үнийг 30 хувиар хөнгөлж импортын элит үрийн худалдах үнийг 660.0 мянган төгрөг, 1 дүгээр үржүүлгийн үрийг 620.0 мянган төгрөг, дотоодын ургацаас нөөц бүрдүүлсэн сортын үрийг 570.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож 10-30 хувийн урьдчилгаатай, шатахууныг 50 хувийн, бордоо, үр ариутгалын болон ургамал хамгааллын бодисыг 30 хувийн урьдчилгаатай тус тус зээлээр олгож намрын ургацаас нөхөн бүрдүүлэхээр шийдвэрлэв.

"Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийн хүрээнд дунд оврын трактор, бага дунд оврын тракторт тохирох хүнсний ногооны иж бүрдэл техникийг 10 хувийн урьдчилгаа төлбөртэй 7 жилийн хугацаатай хүүгүй зээлээр, түүнчлэн хүнсний ногооны 14 нэр төрлийн 18 тонн үрийг өрхийн тариалан эрхлэгчдэд аймаг, нийслэлийн ХХАА-н газраар дамжуулан буцалтгүйгээр олгоно.

Мөн "Жимс, жимсгэнэ" хөтөлбөрийн хүрээнд чацаргана, алым, чавга, үхрийн нүд зэрэг жимс жимсгэнийн 191.0 мянган ширхэг суулгацыг зээлээр олгохын зэрэгцээ 5 га-ийн дуслын усалгааны төхөөрөмжийг 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай, 720 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмжийг 30 хувийн урьдчилгаатай, 4 жилийн хугацаатай тус тус хүүгүй зээлээр олгож байна.

**БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд трактор, хадлан тэжээлийн зориулалттай техник, тоног төхөөрөмж нийлүүлэхээр ажиллаж байгаагийн зэрэгцээ ОХУ-д үйлдвэрлэсэн үр тарианы үрлүүр сийрүүлүүр, хор цацагч, үтрэмийн техникийг 30 хувийн урьдчилгаа төлбөртэй 5.6 хувийн хүйтэй 3-4 жилийн хугацаатай зээлээр олгож байна.**

**4. Хаврын тариалалт эхлэх гэж байгаатай холбогдуулан тариаланчдыг хэрхэн дэмжих, намар хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан төрийн захиргааны байгууллагаас ямар арга хэмжээ авч байгаа талаар:**

Энэ онд улсын хэмжээгээр 408.9 мянган га-д үр тария, үүнээс 390.4 мянган га-д улаанбуудай, 15.5 мянган га-д төмс, 8.4 мянган га-д хүнсний ногоо, 32.0 мянган га-д тэжээлийн таримал, 41.9 мянган га-д тосны ургамал, 6.5 мянган га-д жимс жимсгэнэ, нийтдээ 513.2 мянган га-д тариалалт хийж, 538.4 мянган тонн үр тария, үүнээс 518.7 мянган тонн улаанбуудай, 171.2 мянган тонн төмс, 101.9 мянган тонн хүнсний ногоо, 64.0 мянган тонн малын тэжээл, 34.2 мянган тонн тосны ургамал, 3.0 мянган тонн жимс, жимсгэнэ тус тус хураан авах зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү зорилтын хүрээнд үр тария, тос, тэжээлийн таримлын тариалалтыг 14 аймгийн 1480 гаруй аж ахуйн нэгж иргэн, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэй тариалалтыг 470 гаруй аж ахуйн нэгж, хоршоо, 35.0 мянган өрхийн хэмжээнд тариалахаар бэлтгэлээ хангаж байна.

Тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн 700 гаруй тариаланч, ногоочид, жимсчид оролцсон Улсын зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулж 2018 оны зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, тариалалтын технологийн талаар санал солилцсоны зэрэгцээ Засгийн газрын "Хүнсний ногоо, "Жимс жимсгэнэ" үндэсний хөтөлбөрүүдийн нээлтийн арга хэмжээг хамтатган зохион байгуулав.

Мөн Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жилийн ой 2019 онд тохиож байгаатай холбогдуулан Засгийн газраас ой утсан "Атар-60" хоёр жилийн бүтээлч ажлын төлөвлөгөөг батлан гаргаж тариаланчиддаа танилцуулав.

Түүнчлэн хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд Төв, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Булган аймгийн тариаланчдын зөвлөгөөнд яамнаас төлөөлөл оролцож тариалангийн салбарын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээгээ танилцуулан санал авч ажиллав.

Төрөөс тариалангийн салбарт эрх зүйн болон эдийн засгийн шинэчлэл хийж улмаар байгаалийн эрсдлээс хараат бусаар тариалангийн салбарын хөгжлийг тогтвортжуулахад чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Үүнд тариалалтад дутагдах үрийн нөөцийг бүрдүүлж үнийг хөнгөлөн 10-30 хувийн урьдчилгаатай, бордоо, ургамал хамгааллын бодисыг 30 хувийн, шатахууныг 50 хувийн урьдчилгаатай зээлээр олгож байгаагийн зэрэгцээ техник тоног төхөөрөмжийг 20-30 хувийн урьдчилгаатай 5 хүртэл жилийн хугацаатай зээлээр олгох шийдвэр гарган хэрэгжүүлж байна.



Б.БАТЗОРИГ